



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 355

Улаанбаатар хот

“Даатгалын компанийн дүрмийн сангийн
доод хэмжээг шинэчлэн тогтоох” тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 6 тэрбум төгрөг, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 15 тэрбум төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр заалтаар тогтоосон даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг уг тогтоол гарахаас өмнө даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө бүрдүүлсэн байх, 2013 оноос эхлэн дурдсан хугацааг хүртэл жил тутамд ердийн даатгагч 750 сая, урт хугацааны даатгагч 1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж байхыг даатгалын компаниудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН